

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 дүгээр сарын 17-ны өдөр

дугаар 06

Дархан –Уул аймаг

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйл, Компанийн дүрмийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.3 дахь заалтууд, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Компанийн 2022 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 0,27 төгрөг буюу нийт 300,000,000 (гурван зуун сая) төгрөгийг компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон хуваарилсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй компанийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 2-т заасан ногдол ашгаас холбогдох хууль тогтоомжийн дагуу Хувь хүний орлогын албан татвар болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, ногдол ашгийг “Үнэт цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв” ТӨХХК-аар дамжуулан, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор олгосугай.
4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Дархан Нэхий ХК-ийн Ерөнхий захирал /Б.Чинчулуун/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Х. ЗОЛЖАРГАЛ